

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/18/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichnkhorlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. Аудитын тайлан	14
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт.....	17
Төлбөрийн акт тогтоогоогүй болно.....	17
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар



ТАРИАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГА
ДАРГА Х.ЭГИЙМАА ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.23 № 01/280
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудаас ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэнээр 9,100.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 331.5 сая төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 510.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч нэр төрлөөр нь авч үзвэл 24.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тариалан сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 94.1 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт

олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,191,425.3	1,174,538.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	336,538.1	783,452.2
33	АВЛАГА	374,113.2	214,975.4
35	БАРАА МАТЕРИАЛ	480,774.0	176,110.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,291,856.3	3,421,511.8
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	100,000.0	80,625.0
37300	Урт хугацаат зээл	100,000.0	80,625.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,191,856.3	3,340,886.8
39200	Биет хөрөнгө	11,871,778.7	3,197,667.8
39300	Биет бус хөрөнгө	320,077.6	143,219.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,483,281.6	4,596,050.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	182,416.6	108,729.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	182,416.6	56,890.8
41300	Өглөг	182,416.6	56,890.8
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	51,839.0
42200	Урт хугацаат зээл	0.0	51,839.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,300,865.0	4,487,320.2
51	Засгийн газрын хувь оролцоо	13,300,865.0	4,487,320.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,714,265.7	837,196.6
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	0.0	15,104.7
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,714,265.7	822,091.9
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	257,211.1	438,304.0
51200	Хуримтлагдсан үр дүн	5,754,380.3	1,936,080.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,575,007.9	1,275,739.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13,483,281.6	4,596,050.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,498,545.9	1,890,890.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	366,029.5	1,074,590.0
110	Орлогын албан татвар	116,411.1	453,589.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	116,411.1	492,464.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-38,874.6
113	Хөрөнгийн албан татвар	36,021.4	99,152.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	213,597.0	521,847.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	283,321.4	-555,493.7
120	Нийтлэг татварын бус орлого	283,321.4	-555,493.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,849,195.0	1,371,794.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,280,145.1	1,348,159.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,280,145.1	1,348,159.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,000,875.8	1,284,787.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,735,286.9	456,050.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	359,469.6	56,814.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,161.8	114,271.8
2104	Хангамж, бараа материалын зардал	147,454.7	46,874.2
2105	Нормативт зардал	886,929.3	92,276.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,185.2	47,656.0
2107	Томилолт, зочны зардал	5,909.6	3,872.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	129,324.4	178,804.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	596,154.4	288,167.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	279,269.3	63,372.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	218,400.8	542,730.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	125,570.9	9,432,046.7

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	92,829.9	-8,889,315.8
----	---	----------	--------------

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	7,706,880.1	2,758,043.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	366,029.5	1,074,590.0
110	Орлогын албан татвар	116,411.1	453,589.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	116,411.1	492,464.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-38,874.6
113	Хөрөнгийн албан татвар	36,021.4	99,152.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	213,597.0	521,847.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	23,869.6	42,396.4
1181	Газрын төлбөр	12,831.8	31,016.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	176,895.5	448,434.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,018,193.4	311,658.9
120	Нийтлэг татварын бус орлого	1,018,193.4	311,658.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,322,657.2	1,371,794.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,391,471.2	2,140,143.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,391,471.2	2,140,143.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,472,035.4	1,734,196.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,929,461.3	676,587.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	422,575.4	123,127.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	760,158.1	105,764.8
2104	Хангамж, бараа материалын зардал	491,631.3	450,890.7
2105	Нормативт зардал	524,791.6	92,276.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,938.4	50,288.4
2107	Томилолт, зочны зардал	5,909.6	3,872.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	247,771.3	176,523.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,798.4	54,866.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,919,435.8	405,947.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	315,408.9	617,899.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	450,832.9	75,985.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	450,832.9	75,985.2
2200	Дотоод эх үүсвэрээр	450,832.9	75,985.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-450,832.9	-75,985.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-115,000.0	-95,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000.0	90,000.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	15,000.0	5,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-250,424.0	446,914.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	586,962.0	336,538.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	336,538.1	783,452.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,056,387.2	13,056,387.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	8,060.4	8,060.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,064,447.5	13,064,447.5
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-8,060.4	-8,060.4
7	Өмчид гарсан өөрчилөлт	166,647.9	166,647.9
8	Зарласан ногдол ашиг	-15,000.0	-15,000.0

Хөвсгөл аймгийн Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

9	Тайлант үеийн үр дүн	92,829.9	92,829.9
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,300,865.0	13,300,865.0
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,300,865.0	13,300,865.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-100,321.9	-100,321.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,200,543.0	13,200,543.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	181,092.9	181,092.9
18	Зарласан ногдол ашиг	-5,000.0	-5,000.0
19	Тайлант үеийн үр дүн	-8,889,315.8	-8,889,315.8
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,487,320.2	4,487,320.2

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт /Хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,201,468.6	1,980,296.1	221,172.5	90.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,051,468.6	1,890,296.1	161,172.5	92.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,534,743.5	1,511,535.6	23,207.9	98.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	464,690.3	452,806.8	11,883.5	97.4
210101	Үндсэн цалин	399,646.3	364,886.2	34,760.1	91.3
210102	Нэмэгдэл	48,779.3	64,398.2	(15,618.9)	132.0
210104	Урамшуулал	16,264.7	23,522.3	(7,257.6)	144.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,233.6	56,814.2	419.4	99.3
210201	Тэтгэврийн даатгал	38,777.4	38,781.7	(4.3)	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,615.3	4,556.7	58.6	98.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,692.1	3,655.6	36.5	99.0
210204	Ажилгүйдлийн даатгал	918.5	873.9	44.6	95.1
210205	Эрүүл мэндийн даатгал	9,230.3	8,946.3	284.0	96.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	796,800.8	790,212.1	6,588.7	99.2
210301	Гэрэл, цахилгаан	31,050.0	27,286.4	3,763.6	87.9
210302	Түлш, халаалт	753,151.5	750,326.3	2,825.2	99.6
210303	Цэвэр, бохир ус	12,599.3	12,599.3	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	37,617.3	37,596.2	21.1	99.9
210401	Бичиг хэрэг	6,864.0	6,967.0	(103.0)	101.5
210402	Тээвэр, шатахуун	25,192.5	25,068.4	124.1	99.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,140.0	4,140.0	-	100.0
210404	Ном, хэвлэл	220.8	220.8	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200.0	1,200.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,573.8	54,573.6	0.2	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,485.4	5,485.2	0.2	100.0
210604	Урсгал засвар	49,088.4	49,088.4	-	100.0
2107	Томиллолт, зочны зардал	3,900.0	3,872.0	28.0	99.3
210702	Дотоод албан томилолт	3,900.0	3,872.0	28.0	99.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,227.7	62,668.9	2,558.9	96.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,776.4	62,217.8	2,558.6	96.1
210803	Даатгалын үйлчилгээ	54.5	54.5	0.0	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45.5	45.5	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33.2	33.0	0.2	99.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198.0	198.0	-	100.0
210807	Газрын төлбөр	120.1	120.1	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,700.0	52,992.0	1,708.0	96.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,200.0	35,492.4	1,707.6	95.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,500.0	17,499.6	0.4	100.0

Хөвсгөл аймгийн Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	516,725.1	378,760.5	137,964.6	73.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	480,176.0	342,574.9	137,601.1	71.3
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	480,176.0	342,574.9	137,601.1	71.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,549.1	36,185.6	363.5	99.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,049.1	32,695.6	353.5	98.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500.0	3,490.0	10.0	99.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150,000.0	90,000.0	60,000.0	60.0
230001	Эргэж төлөгдөх зээл	150,000.0	90,000.0	60,000.0	60.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,201,468.6	2,085,352.7	116,115.9	94.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	242,501.7	242,501.7	0.0	100.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	242,501.7	242,501.7	0.0	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,628,415.9	1,759,591.2	(131,175.3)	108.1
320001	Орон нутгийн төсвөөс	1,628,415.9	1,759,591.2	(131,175.3)	108.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	330,551.0	83,259.9	247,291.1	25.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.0	72,270.7	(22,270.7)	144.5
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000.0	10,989.2	(4,989.2)	183.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	274,551.0	-	274,551.0	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	159,633.2	(159,633.2)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	243,048.9	(243,048.9)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/ ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	119,505.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	119,505.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	119,505.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,244.00
210104	Урамшуулал	3,244.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,278.00
210401	Бичиг хэрэг	915.30
210402	Тээвэр, шатахуун	8,362.70
2105	Нормативт зардал	92,276.00
210502	Хоол, хүнс	92,276.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,833.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,833.43
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,874.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,874.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	119,505.43
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	119,505.43
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	90,276.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,093.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,036.40
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,100.03

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь "Хүний хөгжлийг эрхэмлэн дээдэлсэн удирдлагын зөв тогтолцоотой, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангасан, өөрийгөө тэтгэсэн, тогтвортой эдийн засаг бүхий жишиг сум болох" гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна

Тариалан сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 93.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх хяналтыг тавьж ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд орон нутгийн ерөнхий орлого болон 6 төсөвт байгууллага, 2 орон нутгийн сан, 1 орон нутгийн өмчит ХХК нийт 10 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Үүнээс Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль мөн Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу эрүүл мэндийн төв болон Соёлын төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгжийг Засаг даргын 2020 оны А/71 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын нэгж нь 2022 онд 8 ажил хийхээр төлөвлөж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын орон нутгийн орлого бүрдүүлэлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэл, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын тээврийн хэрэгслийн хувийн хэрэг, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн

тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,887.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	336.5	783.5	446.9
Авлага	374.1	215.0	(159.1)
Бараа материал	480.8	176.1	(304.7)
Урт хугацаат зээл	100.0	80.6	(19.4)
Үндсэн хөрөнгө	12,191.9	3,340.9	(8,851.0)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,483.3	4,596.1	(8,887.2)
Богино хугацаат өр төлбөр	182.4	56.9	(125.5)
Урт хугацаат өр төлбөр	-	51.8	51.8
Засгийн газрын хувь оролцоо	13,300.9	4,487.3	(8,813.5)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13,483.3	4,596.1	(8,887.2)

Эх сурвалж: Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн байдлын тайлан

Тайланд онд мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр, үндсэн хөрөнгө, бараа материал дансанд дараах хөдөлгөөн хийгдсэн байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 446.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд орон нутгийн орлого давж биелсэнтэй холбоотой байна.
2. Авлага дансны үлдэгдэл 159.1 сая төгрөгөөр буурахад эрүүл мэндийн төвийн авлагын эхний үлдэгдэл 168.8 сая төгрөг улсын төсөвт шилжсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.
Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 126.4 сая төгрөг байгаа ба үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 5 иргэнтэй холбоотой 35.9 сая төгрөг байна.
3. Бараа материалын дансны үлдэгдэл буурахад төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан ерөнхий боловсролын сургууль, эрүүл мэндийн төв, хүүхдийн цэцэрлэг, соёлын төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэнээр нийт 331.5 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн нь нөлөөлсөн байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль 137.1 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 94.9 сая төгрөг, эрүүл мэндийн төв 72.7 сая төгрөг, соёлын төв 26.7 сая төгрөгийн бараа материалыг тус тус шилжүүлсэн байна.
4. Урт хугацаат зээл 19.4 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангаас 90.0 сая төгрөгийн зээлийг олгосон байна.
5. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь Ерөнхий боловсролын сургууль 2,424.6 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 1,929.9 сая төгрөг, эрүүл мэндийн төв 676.7 сая төгрөг, соёлын төв 3,936.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт тус тус шилжүүлсэнтэй холбоотой байна.

- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 125.5 сая төгрөгөөр буурахад Соёлын төвийн 68.9 сая төгрөгийн халаалтын өр улсын төсөвт шилжсэн нь гол нөлөөг үзүүлсэн байна.
- Урт хугацаат өр төлбөр дансанд Тариалан нийтийн ахуй үйлчилгээний төв ХХК-ийн хойшлогдсон татварын өр 51.8 сая төгрөгийг тайлагнасан байна.

Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 1,890.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 3,607.6 сая төгрөгөөр буюу 34.4 хувиар буурсан байна.

Хүснэгт №2 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	366.0	1,074.6	708.6	293.6
Татварын бус орлого	283.3	-555.5	-838.8	-196.1
Тусламж санхүүжилтийн орлого	4,849.2	1,371.8	-3,477.4	28.3
Нийт дүн	5,498.5	1,890.9	-3,607.6	34.4

Эх сурвалж: Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан байгууллагууд улсын төсөвт шилжсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 2,546.2 сая төгрөгийн 31 орлогын давхардсан гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 2,524.8 сая төгрөгийн 21 орлогын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 1,348.1 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт №3: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөг/	
			Өсөлт бууралт	Хувь
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,000.9	1,284.8	(3,716.1)	25.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,735.3	456.1	(2,279.2)	16.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	359.5	56.8	(302.7)	15.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111.2	114.3	3.1	102.8
Хангамж, бараа материалын зардал	147.5	46.9	(100.6)	31.8
Нормативд зардал	886.9	92.3	(794.7)	10.4
Эд хогшил, урсгал засварын зардал	29.2	47.7	18.5	163.3
Томилолт, зочны зардал	5.9	3.9	(2.0)	65.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	129.3	178.8	49.5	138.3
Бараа үйлчилгээний бусад зардал	596.2	288.2	(308.0)	48.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	279.3	63.4	(215.9)	22.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	125.6	9,432.0	9,306.5	7511.3
НИЙТ ДҮН	5,405.7	10,780.2	5,374.5	199.4

Эх сурвалж: Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт зардлын дүн өмнөх оноос 5,375.5 сая төгрөгөөр өссөн нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан 4 байгууллага улсын төсөвт шилжиж хаалтын тайлан хийсэнтэй холбоотойгоор үйл ажиллагааны бус зардлын дүн 9,306.5 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагааны зардал 3,932.0 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 2,546.2 сая төгрөгийн 31 зарлагын давхардсан гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 2,524.8 сая төгрөгийн 21 зарлагын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсөвт байгууллагуудын төсвийн төслийг 5,739.5 сая төгрөгөөр нэгтгэж аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж ажилласан байна.

Тариалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 2.071.8 сая төгрөгийн төсөв баталснаас 1,645.7 сая төгрөгийг урсгал зардалд, 276.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, Эргэж төлөгдөх зээлийн зардалд 150.0 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,147.2 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 230.5 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 474.6 сая төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 56.0 сая төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс, давсан орлого дансны үлдэгдлээс 163.4 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Тариалан сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн 6 дугаар тогтоолоор төсөвт 129.7 сая төгрөгийн нэмэх тодотгол хийж төсвийг 2,201.5 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Тариалан сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2022 оны 9 дүгээр сарын 14-ны өдрийн 6 дугаар тогтоолд зааснаар Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 618.6 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 1,122.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 181.4 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №4. Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	210.0	309.7	99.7	147.5
Үйл ажиллагааны орлого	25.0	33.6	8.6	134.3
Хөрөнгийн орлого	30.0	43.6	13.6	145.5
Хөрөнгө борлуулсны орлого	6.0	8.4	2.4	139.4
Шууд бус орлого	75.0	97.2	22.2	129.6
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(38.9)	(38.9)	(0.0)	100.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	12.0	13.4	1.4	111.5
Бууны албан татвар	3.8	4.4	0.6	114.8
Малд ногдуулах албан татвар	94.7	81.4	(13.4)	85.9
Улсын тэмдэгтийн хураамж	9.0	28.2	19.2	313.7
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2.9	2.9	-	100.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	8.0	11.3	3.3	141.4
Газрын төлбөр	29.0	31.0	2.0	106.9
Ойн нөөц ашигласны төлбөр	110.5	444.1	333.6	401.9
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1.2	1.3	0.1	107.2
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.1	1.3	0.2	120.3
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1.3	1.7	0.4	134.6
Хувьцааны ногдол ашиг	5.0	5.0	-	100.0
Торгуулийн орлого	23.0	32.9	9.9	143.0
Бусад орлого	10.0	10.0	(0.0)	100.0
НИЙТ ОРЛОГО	618.6	1,122.5	503.8	181.4

Эх сурвалж: Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Тариалан сумын орон нутгийн орлого 503.8 сая төгрөгөөр давж биелэхэд иргэдийн цалин хөлс өссөнөөс цалин хөлс, хөдөлмөр эрхлэлтийн орлого 99.7 сая төгрөгөөр, хувиараа аж ахуй эрхэлж буй иргэдээс орсон татвар болон ноос ноолуурын урамшуулал нэмэгдсэнээс үйл ажиллагааны орлого 8.6 сая төгрөгөөр, иргэдийн хадгаламжийн хэмжээ нэмэгдсэнээс хөрөнгийн орлого 13.6 сая төгрөгөөр, суутгагчийн хувь хүнд олгосон орлогын суутган татвар нэмэгдсэнээс шууд бус орлого 22.2 сая төгрөгөөр, самрын хураамжаас авсан гарал үүслийн зөвшөөрлийн орлого нэмэгдсэнээс улсын тэмдэгтийн хураамж 19.2 сая төгрөгөөр, байгалийн дагалдах баялаг самрын орлого нэмэгдсэнээс ойн нөөц ашигласны төлбөр 333.6 сая төгрөгөөр давж биелсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Орон нутгийн орлогоос малд ногдуулах албан татвар 13.4 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах

болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 134.1 сая төгрөгөөр төлөвлөж 146.0 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 11.9 сая төгрөг буюу 8.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №5: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ААНОАТ	106.8	103.9	(2.9)
2	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	18.9	31.7	12.8
3	Зам ашигласны төлбөр	8.4	10.4	2.0
Нийт дүн		134.1	146.0	11.9

Эх сурвалж: Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл ААНОАТ 2.9 сая төгрөгөөр тасарсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 264.6 сая төгрөгөөр төлөвлөж 259.5 сая төгрөгөөр буюу 98 хувиар гүйцэтгэлийг хангуулсан байна.

Хүснэгт №6: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	118.4	114.9	(3.5)
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	145.2	141.0	(4.2)
3	Агаарын бохирдлын төлбөр	1.0	3.6	2.6
Нийт дүн		264.6	259.5	(5.1)

Эх сурвалж: Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл ААНОАТ 3.5 сая төгрөгөөр, дотоодын бараа үйлчилгээний НӨАТ 4.2 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 1,308.3 сая төгрөгөөр төлөвлөж, 1,335.6 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 102.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 56.0 сая төгрөгийг орлогыг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 83.3 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлтийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 2,201.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,571.3 сая төгрөгийг урсгал зардалд, 480.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 150.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 1,547.8 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 342.5 сая төгрөгийг, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд 90.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,980.3 сая төгрөг буюу 89.9 хувьтай байна.

Хүснэгт №6 Төсвийн гүйцэтгэлийн тайлан /сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ Хэмнэлт	Хувь
II	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,201.47	1,980.30	221.17	90.0
21	Урсгал зардал	2,051.47	1,890.30	161.17	92.1
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	1,534.74	1,511.54	23.21	98.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	464.69	452.81	11.88	97.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57.23	56.81	0.42	99.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	796.80	790.21	6.59	99.2
2104	Хангамж, бараа материалын зардал	37.62	37.60	0.02	99.9

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54.57	54.57	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	3.90	3.87	0.03	99.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65.23	62.67	2.56	96.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54.70	52.99	1.71	96.9
213	Урсгал шилжүүлэг	516.73	378.76	137.96	73.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	480.18	342.57	137.60	71.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	36.55	36.19	0.36	99.0
23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	150.00	90.00	60.00	60.0

Батлагдсан төсвөөс 221.2 сая төгрөгийг зарцуулаагүй нь хоршоо хөгжүүлэх сангаас олгохоор төлөвлөсөн 60.0 сая төгрөгийн зээлийг олгоогүй, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан 5 төсөл арга хэмжээ тайлант онд хэрэгжээгүйгээс 137.6 сая төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд нь хандив тусламжаар 90.3 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 11.1 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 13.1 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 5.1 сая төгрөг нийт 119.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 119.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орлогын биелэлт болон хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/200 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 105.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 84.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан байгууллагууд улсын төсөвт шилжсэнтэй холбоотойгоор материаллаг байдлын түвшнийг тайлант оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,348.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 26.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 21.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчилтэй холбоотой, өр төлбөртэй холбоотой болон шидэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хүргүүлсэн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд тайлант хугацаанд бүрэн биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 7 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	68.7	3	68.7	100
Нийт дүн	3	68.7	3	68.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн ерөнхий орлого болон төсвийн шууд захирагчийн 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Үүнд:

№	Байгууллагын нэр	Аудитын дүгнэлт
1	Засаг даргын Тамгын газар	Өөрчлөлтгүй дүгнэлт
2	Ерөнхий боловсролын сургууль	Өөрчлөлтгүй дүгнэлт
3	Хүүхдийн цэцэрлэг	Өөрчлөлтгүй дүгнэлт
4	Эрүүл мэндийн төв	Өөрчлөлтгүй дүгнэлт
5	Тариалан нийтийн ахуй үйлчилгээний төв ХХК	Өөрчлөлтгүй дүгнэлт
6	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Түүвэрт хамрагдсан
7	Соёлын төв	Түүвэрт хамрагдсан
8	Сум хөгжүүлэх сан	Түүвэрт хамрагдсан
9	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан

Тайлант онд Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эрүүл мэндийн төв болон Соёлын төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэн тул хаалтын тайлан гаргаж нэгтгэсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 182.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд 0.7 сая төгрөгийн 1 алдааг залруулж 3.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 11.8 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 167.3 сая төгрөгийн 3 зөвлөмжийг өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 771.7 сая төгрөгийн алдааг илрүүлж аудитын хугацаанд бүрэн залруулсан. Үүнд:

- Улсын төсөвт шилжсэн харьяа байгууллагуудын хаалтын тайланг үр дүнгийн тайланд нэгтгэхдээ 771.7 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн.

Аудитаар төсөвт төвлөрүүлэх орлогын бүрдэлт болон хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой 59.9 сая төгрөгийн зөрчил илэрч 3 зөвлөмжийг хүргүүлж байна.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 510.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч нэр төрлөөр нь авч үзвэл 24.0 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

2. Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн 5 иргэнтэй холбоотой 35.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361

дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

3. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар

3.1. Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 3.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 11.8 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 167.3 сая төгрөгийн 4 зөвлөмжийг өгсөн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжүүдийг хяналтаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тариалан сумын ТТЗ	1	771.7			1	771.7	1	771.7				
Дүн	1	771.7	0	0	1	771.7	1	771.7	0	0	0	0
Харьяа байгууллагуудын алдаа												
Тариалан НАУТ ХХК	1	0.7			1	0.7	1	0.7				
ДҮН	1	0.7	0	-	1	0.7	1	0.7	0	0	0	0
нийт дүн	2	772.4	0	-	2	772.4	2	772.4	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	3	59.9					3	59.9				
Дүн	3	59.9	0	0	0	0	3	59.9	0	0	0	0
Харьяа байгууллагуудын зөрчил												
Тариалан сумын ЗДТГ	1	3.1	1	3.1								

Хөвсгөл аймгийн Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Тариалан сумын ИТХ	1	11.8			1	11.8					
Тариалан НАҮТ	3	86.1					3	86.1			
Дүн	5	101.0	1	3.1	1	11.8	3	86.1			
Нийт дүн	8	160.9	1	3.1	1	11.8	6	146.0			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТТЗ	0	-						
Харьяа байгууллагуудын зөрчил								
Тариалан НАҮТ	1	21.3					1	21.3
Дүн	1	21.3	0	0	0	0	1	21.3

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 АХЛАХ АУДИТОР
 БАТАЛГААЖУУЛСАН:
 АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЯМ ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

М.Хан